

## Эрүүл мэндийн газрын долоо хоногын мэдээ

### Нэг. Зарим статистик үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	23 дахь долоо хоног	Жилийн эхнээс өссөн дүн	Өмнөх онтой харьцуулахад
1	Нийт төрөлт	62	1260	+4
2	Амьд төрөлт	62	1266	+1
3	Амьгүй төрөлт	0	4	-3
4	Дутуу төрөлт	1	63	-3
5	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	31	+6
6	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	6	-2
7	Эхийн ноцтой хүндрэл	0	1	+1
8	Төрөлхийн гажиг	1	8	+4
9	Гэрийн төрөлт	0	3	+1

### Хоёр. Томуу томуу төст өвчний мэдээ

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 22 дугаар долоо хоногт нийт 4207 хүн үйлчлүүлсний 74(1,7%) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 0,2%-иар өссөн үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (190)-ийн дотор буюу 14,7 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 7,6%-иар өссөн үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 212 дуудлагын 41( 19,3%)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 2,8%-иар өссөн үзүүлэлтэй байна.

### Гурав. Нийгмийн эрүүл мэнд

1. Алтай, Сагсай сумуудын Пневмококк, халдварт саагийн идэвхгүйжүүлсэн вакцины хамралтын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, сургуулийн хүүхдүүдэд Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтын хамралтын судалгаа хийж вакцинд хамрагдаагүй хүүхдүүдийг газар дээр нь Эрүүл мэндийн төв дээр вакцинд

- хамруулсан. Цаашид Цэнгэл, Улаанхус сум, Хөх хөтөл багийн нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийхээр төлөвлөж байна.
2. 2019 оны 05 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд ОХУ-ын Ташант, Кош-Агаш районд "ТАРВАГАН ТАХЛЫН БУЛЧИРХАЙН ХЭЛБЭР" сэдвээр үзүүлэх сургалт зохион байгууллаа. Үүнд: ЭМГ-ын дарга С.Айгул, ЗӨСТөвийн дарга Б.Анаргүл, Лабораторийн эрхлэгч Ч.Үржих, Халдвар судлагч Ж.Балшекер нар оролцлоо.
  3. Аймгийн хэмжээнд Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтын хамралтын байдалд тандалт судалгаа хийгдэж байна.
  4. Эх үрсийн баярыг тохиолдуулан Эрүүл мэндийн газраас тус байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын хүүхдүүдэд гарын бэлэг, мөн байгууллагын одонт эхчүүдэд тус тус бэлэг гардуулав.  
Хүүхэд бүр аз жаргал, баяр хөөрөөр дүүрэн байгаасай!!!
  5. “УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ – УЯАЧ ТАНЫ ХАРИУЦЛАГААС ” ЗӨВЛӨГӨӨНД СУРГАЛТ ЯВУУЛЛАА.  
“Уралдаанч хүүхдэд учирч болзошгүй эрүүл мэндийн эрсдлүүд” сэдвээр 10 сумын 22 уяачдад Бага насны хүүхдэд хурдан морь унуулах нь хүүхдийн эрүүл мэнд, цаашдын амьдрал, амь насанд сөрөг нөлөө үзүүлдэг тул хурдан морины уралдаанч хүүхдүүдийн эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөө, хүүхдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь зөрчигдөхийн зэрэгцээ, эрүүл энх өсч бойжих, эрүүл саруул иргэн болох замд аюул учрах эрсдлүүдийг нь ойлгуулсан үр өгөөжтэй сургалт явууллаа.
  6. Хилийн 0165 дугаар ангийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтанд застасаас ирсэн нөхөн үржэхүйн насны эмэгтэйчүүдийг Раушан ӨЭМТөвд “Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн” үзлэгт хамрагдлаа
  7. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгсэл худалдан авах тендерийг зарлалаа.
  8. Аймгийн төрөх тасгийн ачаалал ихэссэнтэй холбоотой төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж Нэгдсэн эмнэлэгт эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн дотоод халвар гарахаас урьдчилан сэргийлэх, яаралтай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах алван тоот хүргүүлж зааварчилгаа өгч ажилласан.
  9. Эх хүүхдийн дэмжих сангаас нэг жирэмсэн эх, нэг хүүхдийн заардалыг шийдүүлж гуравдугаар шатлалын эмнэлэгт шилжүүлж эмнэлгийн тусламж үзүүлсэн.
  10. “Зөв тусгал” хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдсан “Эцэг, эхийн үүрэг хариуцлага, хүүхдийн хүмүүжил төлөвшил” сэдэвт нийтлэлийн уралдаанд оюун ухаан ур чадвараараа бусдыгаа манлайлж Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн И.Айнагүл дэд байр эзэлсэн болно.